



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1978 оны 7 дугаар
сарын 9 өдөр

Дугаар 9/165

Улаанбаатар
хот

Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг
сайжруулах төслийн хэрэгжлтийг
эрчимжүүлэх зарим арга хэмжээний
тухай

1. Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах Төслийг удирдах нэгжийн дүрмийг хавсралтын ёсоор баталсугай.
2. Төслийг удирдах нэгжийн орон тоог ажил хэрэгч, чадвартай хүмүүсээр бүрдүүлж тэдний ажил үүргийн хуваарийг оновчтой тогтоон үр бүтээлтэй ажиллуулахыг ТУН (н. Бямбаа) – д даалгасугай.
3. Дэлхийн банкаас санхүүжилт хийлгэх ажлыг шуурхай гүйцэтгүүлэх, Дамжуулан зээлдүүлэх зээлийн Гэрээгээр хотоос хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх, санхүүжилттэй холбогдон гарах бүхий л асуудлыг хариуцан шуурхай зохицуулж байхыг Санхүүгийн хэлтэс (н.Гонгор) – т даалгасугай.
4. Төслийн ажлын явц байдлыг захиалагч, гүйцэтгэгч, ашиглагч болон бусад холбогдох байгууллага, хүмүүсийг оролцуулан сар бүр авч хэлэлцэн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэж байхыг Хотын Ерөнхий менежер н. Э.Гомбожавт даалгасугай.
5. Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр хийгдэх ажлыг дүүрэг, хороо бүрээр тодорхой гарган тухайн дүүрэг, хороодод танилцуулан тэдний дэмжлэг тусалцааг авч ажиллахыг Төслийг удирдах нэгж (н.Бямбаа), Ус Сувгийн ашиглалтын газар (н.Эрдэнэбаатар) – т даалгасугай.
6. Төслийн хүрээнд хамрагдах барилга барих, шугам сүлжээ тавих хэсгийг Төслийг удирдах нэгжтэй хамтран газар дээр нь зургийн дагуу судлан үзэж, зураг төсөл хийхээс өмнө зөвшөөрөлтэй буусан айл өрх байвал тэднийг нүүлгэх зардлын нь хамт тооцон гаргаж, газар чөлөөлөх, зөвшөөрөлгүй буусан айл өрхийг нүүлгэх арга хэмжээ авахыг Газрын харилцаа, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн алба (н.Даваабаатар), дүүргүүдийн Засаг дарга нарт даалгасугай.
7. Барилгын ажил гүйцэтгэх хугацаа, чанарт Ус сувгийн ашиглалтын газар, хот байгуулалт, инженерийн байгууламжийн хэлтэстэй хамтран тогтмол

162

хяналт тавьж, илэрсэн зөрчлийг тухай бүрд нь шуурхай барагдуулж байхыг Барилга хөрөнгө оруулалт, захиалагчийн товчоо (н.Ганхүү), Төслийг удирдах нэгж (н.Бямбаа) – д даалгасугай.

8. Төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд буй болсон эд хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшүүлэх ажлыг зохион байгуулахыг нийслэлийн Өмчийн газар (н.Буямөнх) – т даалгасугай.
9. Урьд өмнө хийгдсэн болон цаашид хийгдэх бүх төрлийн зураг төсөл мөрдөгдөж буй норм, норматив, техникийн шаардлагын дагуу хийгдэж байгаа эсэхэд мэргэжлийн хяналт тавин зохих шийдэл гаргаж байхыг Хот байгуулалт инженерийн байгууламжийн хэлтэс (н.Нямсүрэн) – т даалгасугай.
10. Цаашид зураг төсөв боловсруулах, зурганд өөрчлөлт оруулах ажлыг тодорхой хүмүүст хариуцуулан хийлгэж байхаар Төслийг удирдах нэгжтэй гэрээ байгуулан ажилаахыг Нийслэлийн хот байгуулалтын хүрээлэн (н.Оргил) – д даалгасугай.
11. Төсөл хэрэгжүүлэх ажлыг байгууллагын зүгээс дагнан хариуцах мэргэжлийн хүн томилон Төслийг удирдах нэгж болон гадаадын зөвлөхийн мэргэжлийн удирдлага дор ажиллуулахыг Ус сувгийн ашиглалтын газар (н.Эрдэнэбаатар), Орон сууц нийтийн аж ахуйн компани (н.Бямбасүх) – д даалгасугай.
12. Гэр хорооллын хог хаягдлыг зайлуулах ажлын зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хог хаягдлын хураамжийг бүрэн авах, ядуу иргэдийн хог хаягдлын хураамжийг хэрхэн төлөх арга зам зэргийг Дэлхийн банкнаас тавьж байгаа шаардлагын дагуу эцэслэн боловсруулахыг Хот тохижуулах хэлтэс (н.Өлзий) – т даалгасугай.
13. Дэлхийн банкны хөнгөлттэй зээлээр хэрэгжүүлэх Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах төслийн ач холбогдол, ажлын явц байдлын талаар тогтмол сурталчилж байхыг "Улаанбаатар" сонин (н.Хүрэлбаатар), "Дөрвөн уул" радио (н.Сонинтогс), "Улаанбаатар" телевиз (н.Балхжав) – д тус тус даалгасугай.
14. ТУН – д ажиллаж байгаа гадаадын зөвлөхүүдийн болон Төслийг удирдах нэгжийн хэрэгцээнд сандал, төмөр сейф авахад шаардагдах 850,0 мянган төгрөгийг Нийслэлийн 1998 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгөөс зохицуулан гаргахыг Стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (н.Бат), Өмчийн газар (н.Буямөнх) – т зөвшөөрсүгэй.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ж.НАРАНЦАЦРААЛТ



Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 1998 оны 7 дугаар сарын 9 ны өдрийн 8/16 дугаар захирамжийн хавсралт

УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙГ САЙЖРУУЛАХ ТӨСЛИЙГ УДИРДАХ НЭГЖИЙН

ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Төслийг Удирдах нэгж (ТУН) нь Дэлхийн банкны хөнгөлттэй зээлээр хийгдэх Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах төслийг хэрэгжүүлэх өдөр тутмын ажлыг Нийслэлийн нэрийн өмнөөс хариуцан зохион байгуулна.
- 1.2 Хотын нийтийн аж ахуйг сайжруулах төслийг удирдах нэгж (ТУН) нь нийслэлийн Засаг дарга бөгөөд хотын захирагчийн шийдвэрээр байгуулагдаж Захирагчийн ажлын албаны удирдлаганд ажиллана.
- 1.3 Нэгжийн орон тоо зохион байгуулалтыг ОУХА, Захирагчийн ажлын алба, Сангийн яам харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.
- 1.4 ТУН нь 2001 оныг буюу төслийн хэрэгжилтийг дуустал үйл ажиллагаа явуулна. Нэгж нь хотын Санхүүгийн хэлтэст бүртгүүлж гэрчилгээ авна.
- 1.5 ТУН нь албан хэрэгтээ тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Төслийг удирдах нэгжийн үүрэг.

- А. Төслийг удирдах нэгж нь удирдлага, зохион байгуулалтын ажилтай холбогдуулан дараахь үйл ажиллагаа явуулна. Үүнд:
- 2.1 Орон нутгийн зөвлөх мэргэжилтнүүдийн боловсруулах дараа дараагийн жилүүдийн зураг төслийн ажлын төлөвлөгөө болон бусад судалгааны техникийн тодорхойлолтыг гаргуулах, орон нутгийн зөвлөх мэргэжилтнүүдийн ажилд хяналт тавих;
 - 2.2 Төслийн хэрэгжилтийн хоёр дахь жилээс тав дахь жил хүртэл жил бүр гүйцэтгэх ажлын сонгон шалгаруулалтын бичиг баримт, түүний хэрэгжилтийн төлөвлөгөө боловсруулах;
 - 2.3 Сонгон шалгаруулалтанд оролцох гүйцэтгэгч байгууллагын саналыг хүлээн авахаас эхлэн шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах зэрэг ажлыг ОУХА-н чиглэлийн дагуу удирдан зохион байгуулах;
 - 2.4 Нийлүүлэх тоног төхөөрөмжийн өртгийн үнэлгээг судлах;

2.5 Сонгон шалгаруулалтанд ирүүлсэн саналуудад техникийн үнэлгээ хийж, тендерийг үнэлэх ажлын хэсэгт туслаалцаа үзүүлэх;

2.6 Гүйцэтгэгч байгууллагаас үзүүлсэн ажлын гүйцэтгэлийн нэхэмжлэхийг захиалагчтай хамтран хянан шалгаж Захирагчийн ажлын алба, Сангийн яаманд тодорхой хугацаанд оруулж байх;

2.7 Ажлын төлбөр, зээлийн зарцуулалтад тогтоосон журмын дагуу санхүү, нягтлан бодох бүртгэл хөтөлж байх;

2.8 Хагас жил бүр тайлан гаргаж Сангийн Яам, ОУХА-т хүргүүлэх;

2.9 Дэд бүтцийн хөгжлийн Яам, Захирагчийн ажлын алба зэрэг холбогдох байгууллагуудтай хамтран зээлийн хүрээнд хэрэгжүүлсэн судалгааг хянан шалгах;

2.10 Үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтүүд нь ажлын зорилготой нийцэж байгаа эсэхийг хянах, шинэчлэн өөрчлөх;

2.11 Ус сувгийн ашиглалтын газар, Орон сууц, нийтийн аж ахуйн компани зэрэг байгууллагуудын хариуцах төслийн ажлын хэрэгжилтэнд туслаалцаа үзүүлэх (үүнд: бодит ажил гүйцэтгэх болон зохион байгуулалтын асуудлууд);

2.12 Гэр хорооллын оршин суугчдын олон нийтийн оролцоог хөхүүлэн дэмжих;

2.13 Хуурай хог тээвэрлэлтийн болон гэр хорооллын дэд бүтцийн үйлчилгээг сайжруулах, хэрэглэгчдийн төлбөр хураамж ноогдуулах зэрэг шаардлагатай арга хэрэгсэл зохион байгуулах ажилд хороод болон олон нийтэд туслаалцаа үзүүлэх.

Б. Төслийн Гэрээгээр хийгдэж буй ажлын гүйцэтгэлийг газар дээр нь хянан шалгах ажилтай холбогдуулж дараахь үйл ажиллагаа явуулна. Үүнд:

2.14 Импортоор оруулж ирэх бараа, материал тоног төхөөрөмжийн нөхцөл байдлыг хэрэгжүүлэгч буюу гүйцэтгэгч байгууллагад хүргэх, дамжуулахаас өмнө шалгах;

2.15 Орон нутгийн болон гадаадын зөвлөх мэргэжилтнүүдийн ажлын бодит гүйцэтгэл, гэрээгээр гүйцэтгэсэн ажлын чанарт хяналт тавих;

2.16 Гүйцэтгэсэн ажлыг хянан шалгаж, үүнтэй уялдуулан тайлан боловсруулах;

2.17 Ерөнхий нөхдлүүдэд өөрчлөлт орох тохиолдолд нарийвчилсан ажлын зураг төсөлд өөрчлөлт оруулах;

2.18 Гэрээнүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага гарсан тохиолдолд тэдгээрийг боловсруулах;

2.19 Техникийн туслаалцааны төслийн хүрээнд боловсруулсан хэд хэдэн хөтөлбөрийг (хуурай хог, гэр хорооллын дэд бүтцийн хэрэглэгчдийн төлбөр зэрэг) хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

Гурав. Төслийг Удирдах нэгжийн эрх

3.1 Орон нутгийн болон гадаадын зөвлөх мэргэжилтнүүдийн боловсруулсан зураг төсөл, газрын зураглалын болон бусад судалгаа, төлөвлөгөөг шаардлагын хэмжээнд хийлгэх;

3.2 Гэрээгээр хийгдэж буй ажлыг зохих шаардлага хангах хэмжээнд засуулах, нэмэлт хийлгэх;

3.3 Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаа явуулахтай холбогдуулан төсвийг зохиож холбогдох байгууллагуудтай зөвшилцөн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд хотын Захирагчаар батлуулж мөрдөх;

Дөрөв. Төслийг Удирдах нэгжийн санхүүжилт

4.1 Төслийг Удирдах нэгжийн зардлыг дараахь гол хоёр эх үүсвэрээс гаргана. Үүнд:

- (а) Төслийн тусгай дансанд орох ОУХА-н зээл;
- (б) Төслийн нийт өртөгийн 10 хувь болох Монголын Засгийн газрын хөрөнгө оруулалт буюу Нийслэлийн төсвөөс.

4.2 Нэгж нь өдөр тутмын үйл ажиллагаатай холбогдсон зардлыг нарийн тооцон батлагдсан хэмжээнд нь багтаан зарцуулна.

Тав. Нэгжийн боловсон хүчин

5.1 Нэгж нь батлагдсан орон тооны дагуу байнгын ажилтнуудтай байхын зэрэгцээ тодорхой ажлуудыг орон нутгийн зөвлөх мэргэжилтнүүдээр гэрээний үндсэн дээр хийлгэж, гадаадын зөвлөх мэргэжилтнүүдийг төслийн хэрэгжилтийн эхний 2 жилийн хугацаанд авч ажиллуулна.

5.2 Нэгжийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд хотын Захирагчийн томилсон Захирал удирдана. Захирал нь зохих хууль тогтоомжид нийцүүлэн эрхэлсэн ажлын хүрээнд тушаал гаргаж, Засаг даргын эрх олгосноор эрх хэмжээний хүрээний асуудалтай холбогдолтой гэрээ хэлцэлд гарын үсэг зурна.

Зургаа. Нэгжийн хариуцлага

6.1 Нэгж нь Хотын нийтийн аж ахуйг сайжруулах төслийг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлэх ажлыг хариуцна.